Эх сурвалж: Заг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 246,412.3 мянган төгрөг болж өмнөх оноос 5,897.2 мянган төгрөгөөр буурсан нь Соёлын төв 2,741.9 мянга, сумын Сургуулийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн "Тусгай зориулалтын эд хөрөнгө актлах тухай" 101 дугаартай тушаалаар 32,587.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-----------------|------------------|------------------|------------------------|-----------------|
| ИТХ | 1,187.9 | 3,590.9 | 2,403.0 | 1.5 |
| ЗДТГ | 66,249.9 | 69,167.8 | 2,917.9 | 28.1 |
| Соёл | 13,863.5 | 11,121.6 | -2,741.9 | 4.5 |
| ЭМТ | 28,203.0 | 43,384.7 | 15,181.7 | 17.6 |
| ОНХС | 0.0 | 4,714.8 | 4,714.8 | 1.9 |
| ЕБС | 99,049.3 | 67,975.2 | -31,074.1 | 27.6 |
| Цэцэрлэг | 43,755.9 | 46,457.3 | 2,701.4 | 18.9 |
| НИЙТ ДҮН | 252,309.5 | 246,412.3 | -5,897.2 | 100.0 |

Эх сурвалж: Заг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 299,977.5 мянган төгрөгийн бараа материалын 259,962.9 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, хандив тусламжаар 25,069.3 мянга, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас өвсний үнэ 5,000.0 мянга, мөн 9,945.3 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,705,650.8 мянга, эцсийн үлдэгдэл 6,419,734.5 мянган төгрөг болж 1,714,083.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-------------------------------|--------------------|--------------------|------------------------|-----------------|
| БИЕТ ХӨРӨНГӨ | 4,655,448.8 | 6,367,706.0 | 1,712,257.2 | 99.2 |
| Барилга байгууламж, орон сууц | 3,018,434.1 | 4,579,851.90 | 1,561,417.8 | 71.3 |
| Тээврийн хэрэгсэл | 176,684.8 | 154,184.80 | -22,500.0 | 2.4 |
| Машин тоног төхөөрөмж | 586,933.2 | 667,788.40 | 80,855.2 | 10.4 |
| Тавилга эд хогшил | 116,258.0 | 142,222.20 | 25,964.2 | 2.2 |
| Номын фонд | 20,617.4 | 22,597.40 | 1,980.0 | 0.4 |
| Дуусаагүй барилга | 198,105.4 | 198,105.40 | 0.0 | 3.1 |
| Бусад үндсэн хөрөнгө | 538,415.9 | 602,955.90 | 64,540.0 | 9.4 |
| БИЕТ БУС ХӨРӨНГӨ | 50,202.0 | 52,028.5 | 1,826.5 | 0.8 |
| Программ хангамж | 1,530.0 | 3,842.50 | 2,312.5 | 0.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 48,672.0 | 48,186.00 | -486.0 | 0.8 |
| НИЙТ ДҮН | 4,705,650.8 | 6,419,734.5 | 1,714,083.7 | 100.0 |

Эх сурвалж: Заг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нэмэгдсэн 1,714,083.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс Засаг даргын Тамгын газар 69,181.5 мянга, Сургууль 21,679.2 мянга, Цэцэрлэг 360.0 мянга, Соёлын төв 1,579,795.3 мянга, ЭМТөв 9,522.2 мянга, ИТХурал 650.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ны өдрийн “Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 138 дугаар тогтоолын дугуу 1,541,932.2 мянган төгрөгийн өртөг бүхий сумын Соёлын төвийн барилга, ЗДТГ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бусад хөрөнгөнд 64,500.0 мянган төгрөгийн барилга байгууламж, аймгийн ХХААГ-аас 2,381.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй, Сургууль нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.07.31-ны өдрийн “Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай” 54 дүгээр тогтоолоор 1,329.2 мянган төгрөгийн барилгыг шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-----------------|--------------------|--------------------|------------------------|-----------------|
| ИТХ | 16,857.0 | 17,507.0 | 650.0 | 0.3 |
| ЗДТГ | 1,708,127.0 | 1,754,808.5 | 46,681.5 | 27.3 |
| Соёл | 219,158.8 | 1,794,603.5 | 1,575,444.7 | 28.0 |
| ЭМТ | 1,001,182.2 | 1,092,704.5 | 91,522.3 | 17.0 |
| ЕБС | 1,313,989.8 | 1,313,415.1 | -574.7 | 20.5 |
| Цэцэрлэг | 446,336.0 | 446,696.0 | 360.0 | 7.0 |
| НИЙТ ДҮН | 4,705,650.8 | 6,419,734.6 | 1,714,083.8 | 100.0 |

Аудитын код: БНА-2021/4/СТА-ТТЗ

**Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Эх сурвалж: Заг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн зарлага 49,104.6 мянган төгрөг байгаа нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ны өдрийн “Хөрөнгө акталж данснаас хасах тухай” 137 дугаар тогтоолын дагуу Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4,350.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.07.31-ны өдрийн “Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай” 54 дүгээр тогтоолын дагуу Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 21,767.9 мянган төгрөгийн барилгыг газрын хамт шилжүүлж, мөн өдрийн “Хөрөнгө худалдах тухай” 52 дугаартай тогтоолоор ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 14-51БНР улсын дугаартай автомашиныг худалдан борлуулж хөрөнгийг бүртгэлээс хассантай холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Сумын ЭМТ-тэй холбоотой өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,797.7 мянган төгрөгийг тайлант онд 100 хувь барагдуулсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

| № | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Үүнээс: | | |
|---|------------------|----------------|-----------------|-------------------------|--------------------------|----------------------------------|
| | | | | Ажиллагсадтай холбоотой | Байгууллагад төлөх өглөг | Бараа үйлчилгээний зардлын өглөг |
| 1 | ОНХС | | | | | |
| 2 | ЕБС | | | | | |
| 3 | Цэцэрлэг | | | | | |
| 4 | ЭМТ | 5,797.7 | | | | |
| 5 | Соёлын төв | | | | | |
| | ДҮН | 5,797.7 | | | | |

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,149,240.5 мянга, эцсийн үлдэгдэл 6,046,134.9 мянган төгрөг болж, 1,896,894.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд |
|---|--------------------|--------------------|--------------------|--------------|
| | | | | эзлэх хувь |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,483,681.1 | 1,483,681.1 | - | 24.5 |
| Өмч: - төрийн | - | - | - | - |
| Хуримтлагдсан үр дүн | 825,336.8 | 2,743,005.8 | 1,917,669.0 | 45.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,840,222.6 | 1,819,448.0 | (20,774.6) | 30.1 |
| Дүн | 4,149,240.5 | 6,046,134.9 | 1,896,894.4 | 100.0 |

Эх сурвалж: Заг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.20-ны өдрийн “Баянхонгор аймгийн Заг сумын 2021 оны төсөв батлах тухай” хурлын хуралдааны 2/05 дугаартай тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 45,700.0 мянга, хүү торгуулийн орлогыг 5,000.0 мянга, нийт 50,700.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №10. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төвлөлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---------------|------------|-----------|-------|------|
|---------------|------------|-----------|-------|------|

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | |
|--|-----------------|-----------------|-----------|-------|
| 1.Татварын орлого | 45,700.0 | 58,234.2 | 12,534.2 | 127.4 |
| ИОТХ | 4,500.0 | 17,631.9 | 13,131.9 | 391.8 |
| Бууны татвар | 2,000.0 | 1,526.0 | (474.0) | 76.30 |
| Улсын тэмдэгийн хураамж | 1,500.0 | 378.7 | (1,121.3) | 25.3 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 27,000.0 | 29,832.9 | 2,832.9 | 110.5 |
| ҮХЭХ борлуулсаны орлого | 3,000.0 | 4,306.4 | 1,306.4 | 143.6 |
| Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж | 500.0 | | (500.0) | - |
| Газрын төлбөр | 1,200.0 | 531.4 | (668.6) | 44.3 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 6,000.0 | 4,026.9 | (1,973.1) | 67.1 |
| 2.Татварын бус орлого | 5,000.0 | 6,441.7 | 1,441.7 | 128.8 |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 5,000.0 | 6,441.7 | 1,441.7 | 128.8 |
| Нийт дүн | 50,700.0 | 64,675.9 | 13,975.9 | 127.6 |

Эх сурвалж: Заг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 12,534.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 13,131.9 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 2,832.9 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 1,306.4 мянга, хүү торгуулийн орлого 1,441.7 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин газрын төлбөр 55.7 хувь буюу 668.6 мянга, бууны татвар 23.7 хувь буюу 474.0 мянга, улсын тэмдэгийн хураамж 74.7 хувь буюу 1,121.3 мянга, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 100 хувь, хог хаягдлын үйлчилгээний хураамж 32.9 хувь буюу 1,973.1 мянган төгрөгийн орлого тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогыг төлөвлөснөөс орлогыг 100 хувь төвлөрүүлсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 29,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 88,213.1 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.5.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн 8 хөтөлбөрт 1,967,199.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,850,111.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,751,127.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 98,984.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 8 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнд ноогдох хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн

Аудитын код: БНА-2021/4/СТА-ТТЗ

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

төлөөлөгчдийн хурлын 2020.12.20-ний өдрийн 2/17 дугаар тогтоолоор нийт 1,948,894.4 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №10. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|------------------------------|--------------------|----------------------|-------------------|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 74,942.3 | 61,229.0 | 13,713.3 |
| Засаг даргын Тамгын газар | 311,065.2 | 337,492.3 | -26,427.1 |
| Сургууль | 606,397.8 | 516,838.8 | 89,559.0 |
| Цэцэрлэг | 251,755.5 | 236,024.4 | 15,731.1 |
| Эрүүл мэндийн төв | 432633.4 | 470,813.2 | -38,179.8 |
| Соёлын төв | 106,789.9 | 128,496.7 | -21,706.8 |
| Сум хөгжүүлэх сан | | 90,000.0 | -90,000.0 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 108,000.0 | -108,000.0 |
| Нийт дүн | 1,783,584.1 | 1,948,894.4 | -165,310.3 |

Эх сурвалж: Заг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.20-ний өдрийн 2/17 дугаар тогтоолоор анх 1,948,894.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.23-ний өдрийн 3/05 дугаар тогтоолоор 57,205.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 38,900.0 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 1,967,199.7 мянган төгрөг болсон бөгөөд сумын ИТХ-ын хуралдаанаар төсвийг нэмж батлаагүй байна.

Нийт зардлын 1,055,774.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 68,885.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 602,322.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 50,700.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 30,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 21,163.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 138,354.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 1,055,774.2 мянга, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтээр 602,332.1 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээр 68,885.2 мянга, туслах үйл ажиллагааны орлогоор 4,195.5 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 14,702.1 мянган төгрөгийг санхүүжилт авч улсын төсөвт 30,401.7 мянга, орон нутгийн төсөвт 41,470.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №11. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Улсын төсөвт төвлөрүүлсэн | ОН төсөвт төвлөрүүлсэн |
|------------------|------------|-----------|----------|------|---------------------------|------------------------|
| ИТХ | 66,229.0 | 65,507.9 | 721.1 | 98.9 | | 721.1 |
| ЗДТГ | 362,689.4 | 339,167.0 | 23,522.4 | 93.5 | | 23522.4 |
| Сургууль | 541,847.4 | 514,787.9 | 27,059.5 | 95.0 | 21,714.7 | |
| Цэцэрлэг | 203,483.9 | 194,651.3 | 8,832.6 | 95.7 | 7,609.1 | |
| Соёлын төв | 124,636.8 | 107,410.2 | 17,226.6 | 86.2 | | 17226.6 |
| Хүн эмнэлэг | 470,313.2 | 462,130.8 | 8,182.4 | 98.3 | 1,077.9 | |

Аудитын код: БНА-2021/4/СТА-ТТЗ

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | |
|-----------------|--------------------|--------------------|------------------|-------------|-----------------|-----------------|
| СХСан | 90,000.0 | 67,472.0 | 22,528.0 | 75.0 | | |
| ОНХСан | 108,000.0 | 98,984.8 | 9,015.2 | 91.7 | | |
| Нийт дүн | 1,967,199.7 | 1,850,111.9 | 117,087.8 | 94.0 | 30,401.7 | 41,470.1 |

Эх сурвалж: Заг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 94.0 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 21,714.7 мянга, Цэцэрлэгийн зардлыг 7,609.1 мянга, ЭМТ-ийн зардлыг 1,077.9 мянга, ИТХ-ын зардлыг 721.1 мянга, ЗДТГ-ын зардлыг 23,522.4 мянга, Соёлын төвийн зардлыг 17,226.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 89,377.5 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 40,963.4 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 101,795.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 230,676.9 мянган төгрөгийг зарцуулж 1,459.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 12. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | ЕБС | ЭМТ | НИЙТ |
|--|---------|----------|----------|-----------|-----------|
| НИЙТ ОРЛОГО | 1,000.0 | 32,581.4 | 43,299.6 | 155,254.9 | 232,135.9 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000.0 | 2,292.0 | 32,625.6 | 53,459.9 | 89,377.5 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 30,289.4 | 10,674.0 | | 40,963.4 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | | | 101,795.0 | 101,795.0 |
| НИЙТ ЗАРЛАГА | 1,000.0 | 31,122.5 | 43,299.6 | 155,254.8 | 230,676.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000.0 | 31,122.5 | 43,299.6 | 155,254.8 | 230,676.9 |
| Төсөвт төвлөрүүлсэн | 0.0 | 1,458.9 | 0.0 | 0.10 | 1,459.0 |

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын Засаг даргын нөөц санг 37,500.0 мянган төгрөгөөр тодотгон баталж нийт 27,521.3 мянган төгрөгийг зарцуулж 9,978.6 мянган төгрөгийн төвлөрүүлэн ажилласан байна.

Нөөц хөрөнгийн зарцуулалтыг сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 65 хувийг журмын 2,1,1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 32 хувийг 2,1,5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд 2,5 хувийг 2,1,6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Сумын Засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 75 арга хэмжээний хэрэгжилтийг 87 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,967,199.7 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,850,111.9 мянган төгрөгийг зарцуулж, 94.1 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 12,534.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 13,131.9 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 2,832.9 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 1,306.4 мянга, хүү торгуулийн орлого 1,441.7 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин газрын төлбөр 55.7 хувь буюу 668.6 мянга, бууны татвар 23.7 хувь буюу 474.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 74.7 хувь буюу 1,121.3 мянга, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 100 хувь, хог хаягдлын үйлчилгээний хураамж 32.9 хувь буюу 1,973.1 мянган төгрөгийн орлого тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогыг төлөвлөснөөс орлогыг 100 хувь төвлөрүүлсэн байна.

Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Заг сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №13. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | |
|------------------|-------------------------------------|--------------------------|--------------------------------|--------|
| | × | Σ | ω | Σ |
| | × <td>Σ <td>ω <td>Σ </td></td></td> | Σ <td>ω <td>Σ </td></td> | ω <td>Σ </td> | Σ |
| | | Гүйцэтгэсэн | | Үүнээс |

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|----------------------|----------|----------|------------------------------|-----------------------|----------|-----------|----------------|----------|--|
| ЕБСургууль | 1 | 1 | 1 | | | 1 | 1 | | |
| Хүүхдийн цэцэрлэг | 1 | 1 | 1 | | | 1 | 1 | | |
| ЗДТГ | 1 | 1 | 1 | | | 1 | 1 | | |
| ИТХурал | 1 | 1 | | 1 | | | | | |
| Соёлын төв | 1 | 1 | | 1 | | | | | |
| ЭМТ | 1 | 1 | 1 | | | 1 | 1 | | |
| ОНХС | 1 | 1 | | 1 | | | | | |
| СХС | 1 | 1 | | 1 | | | | | |
| НИЙТ ДҮН | 8 | 8 | 4 | 4 | 4 | 4 | 0 | 0 | 0 |

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагуудад зөрчилгүй санал дүгнэлтийг өгсөн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 207,899.4 мянган төгрөгийн 18 алдаа, зөрчил илэрснээс 6,692.7 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 4,016.7 мянган төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,803.5 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 195,386.6 мянган төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №14. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|-------------------------|----------|---|---------|-------------------------|---------|-----------------------|---------|---------------|----------|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил | | | | | | | | | | |
| ЕБСургууль | 1 | 61.8 | 1 | 61.8 | | | | | | |
| Хүүхдийн цэцэрлэг | 4 | 2,746.3 | | | 2 | 371.2 | 1.0 | 1,803.5 | 1 | 571.6 |
| ЗДТГ | 3 | 4,520.8 | | | 2 | 1,859.9 | | | 1 | 2,660.90 |
| ОНХСан | 2 | 5,714.8 | 1 | 4,714.8 | 1 | 1,000.0 | | | | |
| ЭМТ | 2 | 2,701.6 | 1 | 1,916.0 | 1 | 785.6 | | | | |
| СХС | 1 | 7,041.0 | | | | | | | 1 | 7,041.0 |
| СТА зөрчлийн дүн | 13 | 22,786.3 | 3 | 6,692.7 | 6 | 4,016.7 | 1 | 1,803.5 | 3 | 10,273.5 |
| СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | |
| ЕБСургууль | 2 | 74,234.5 | | | | | | | 2 | 74,234.5 |
| Хүүхдийн цэцэрлэг | 1 | 54,264.9 | | | | | | | 1 | 54,264.9 |
| ЗДТГ | 1 | 8,000.0 | | | | | | | 1 | 8,000.0 |
| ИТХурал | 0 | - | | | | | | | | |

Аудитын код: БНА-2021/4/СТА-ТТЗ

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | |
|----------------------|----|-----------|---|---------|---|---------|---|---------|---|------------|
| Соёлын төв | 0 | - | | | | | | | | |
| ЭМТ | 1 | 48,613.7 | | | | | | | 1 | 48,613.7 |
| Нийцлийн аудитын дүн | 5 | 185,113.1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 5 | 185,113.12 |
| Нийт дүн | 18 | 207,899.4 | 3 | 6,692.7 | 6 | 4,016.7 | 1 | 1,803.5 | 8 | 195,386.6 |

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 22,786.3 мянган төгрөгийн 13 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 185,113.1 мянган төгрөгийн 5 зөрчил тус тус илэрсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 199 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 13. Шилэн дансны мэдээлэл

| д/д | хугацаа | төрөл | удаа | хугацаанд нь мэдээлсэн | хугацаа хоцроосон | мэдээлээгүй |
|-----|-------------|-------|------|------------------------|-------------------|-------------|
| 1 | Бүтэн жил | 12 | 12 | 10 | 2 | |
| 2 | Хагас жил | 3 | 3 | 3 | 0 | |
| 3 | Улирал бүр | 2 | 8 | 8 | 0 | |
| 4 | Сар бүр | 5 | 60 | 58 | 2 | |
| 5 | Тухай бүр | 6 | 72 | 70 | 2 | |
| | Нийт | 28 | 155 | 149 | 6 | 0 |

Эх сурвалж. Заг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв

Аудитын код: БНА-2021/4/СТА-ТТЗ

захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Заг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Заг сумын Ерөнхий боловсролын сургууль нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 81,840.4 мянган төгрөгөөр баталж 76,495.6 мянган төгрөгийг зарцуулж нийт 16,368.1 мянган төгрөг хэмнэхээс 11,023.3 мянган төгрөгийг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Иймд дээрх зөрчилд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 224,998.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 1/63 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 14 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь Хувь |
|----------|---------------------|-----------|---------|-----------|--------------|-----|---------------------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Зөвлөмж | 2 | 224,998.1 | 2 | 224,998.1 | | | 100.0 |
| Нийт | 2 | 224,998.1 | 2 | 224,998.1 | | | 100.0 |

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй. Харин ЭМТ-ийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтийн 178,200.0 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид өглөг, авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай ба авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

4. Аудитын илрүүлэлт

Заг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй 4 зөвлөмжийг хүргүүлж байна.

4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилттой уялдуулан батлуулж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх.

2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтын дагуу аймгийн Засаг даргын 2021.12.06-ны өдрийн А/742 дугаартай захирамжаар сумын Сургуулийн төсвийг 14,500.0 мянга, Цэцэрлэгийн төсвийг 24,400.0 мянган төгрөгөөр бууруулсан байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх.

3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 207,899.4 мянган төгрөгийн 18 алдаа зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хэрэгжүүлж ажиллаагүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайлан болон ТШЗ-ийн санхүүгийн тайланд илэрсэн алдаа зөрчлийг арилгах тал дээр тавих дотоод хяналтыг сайжруулж, ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллах зөвлөмж өгөв.

Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

4. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Тайлант хугацаанд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|--|-------------------------------------|----------------------|----------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Заг сумын ТТЗ | 3 | 38,900.0 | | | | | | | 3 | 38,900.0 |
| Дүн | | 3 | 38,900.0 | | | | | | | 3 | 38,900.0 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Шилэн дансны хэрэгжилт | 1 | | | | | | | | 1 | |
| Дүн | | 1 | | | | | | | | 1 | |
| Нийт дүн | | 4 | 38,900.0 | | | | | | | 4 | 38,900.0 |

Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Бэлтгэх 1. Заг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх зөрчил

| Огноо | Аудитын нэр: | Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: |
|------------------------------|--------------|---|--------------------|
| 2022.03.25 | | | БНА-2022/4/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Заг сумын Засаг дарга | Мянган төгрөг |

| Д/д | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт. | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|------------------------------|--|----------------------------|------------------------------|---|---------------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Заг сумын Засаг дарга | | 38,900.0 | | | |
| 1 | Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна. | | Зөвлөмж | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Г.Нямжаргал, Д.Дуламсүрэн |
| 2 | Тайлант хугацаанд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | | Зөвлөмж | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Г.Нямжаргал, Д.Дуламсүрэн |
| 3 | Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 207,899.4 мянган төгрөгийн 18 алдаа зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хэрэгжүүлж ажиллаагүй байна | | Зөвлөмж | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Г.Нямжаргал, Д.Дуламсүрэн |

Аудитын код: БНА-2021/4/СТА-ТТЗ

**Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | | | |
|---|---|----------|---------|--|------------------------------|
| 4 | Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу аймгийн Засаг даргын 2021.12.06-ны өдрийн А/742 дугаартай захирамжаар сумын Сургуулийн төсвийг 14,500.0 мянга, Цэцэрлэгийн төсвийг 24,400.0 мянган төгрөгөөр бууруулсан байхад төсөвт тодотгол хийгээгүй байна. | 38,900.0 | Зөвлөмж | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Г.Нямжаргал, Д.Дуламсүрэн |
|---|---|----------|---------|--|------------------------------|

2. Заг сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангаарх зөрчил

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|-----------------|---------------------------------------|---|-----------------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Заг сумын зөрчлийн нэгдсэн дүн | 207,899.4 | | | |
| | Заг сумын ЗДТГ-ын зөрчлийн дүн | 12,520.8 | | | |
| 1 | Засгийн газрын 2020.12.13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" баталсан ба Баянхонгор Чандмань-Баянхонгор ХК-аас усны төлбөрт нэмэлт санхүүжилтийн дансанд 1590.0 мянга, үндсэн дансанд 150.0 мянган төгрөг орлого орсон бөгөөд үүнээс байгууллагын бичиг хэргийн зардалд 931.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 931.0 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Д.Гантуул, Ж.Отгонбаатар |
| 2 | Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 9289.0 мянган төгрөгийг бэлэн авч зарцуулсан ба анхан шатны баримтын бүрдэл дутуу худалдан авсан бараа материалын е баримт хавсаргаагүй, шимтгэл тооцоог суутган тооцоогүй байна. | 928.9 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Д.Гантуул, Ж.Отгонбаатар |
| 3 | Цалингийн цэстээс түүвэр хийж үзэхэд 206,187.8 мянган төгрөгийг зардал гарсан байхад санхүүгийн үр дүнгийн тайлангаар 208,848.7 мянган төгрөгөөр тайлагнаж 2660.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. | 2,660.9 | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | Д.Гантуул, Ж.Отгонбаатар |
| 4 | Тус байгууллага нь 2021 онд нийт 385,381.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээний 8,000.0 мянган төгрөгийг мэдээлээгүй байна. | 8,000.0 | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | Д.Гантуул, Ж.Отгонбаатар |
| | Заг сумын ЕБС-ийн зөрчлийн дүн | 74,296.3 | | | |
| 5 | Байгууллагын хоорондын тооцоогоор НДШ-ийн авлага 61.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. | 61.8 | Залруулга | Захирал, нягтлан бодогч | Б.Март, У.Сүхбаатар |
| 6 | Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 81,840.4 мянган төгрөгөөр баталж 76,495.6 мянган төгрөгийг зарцуулж нийт 16,368.1 мянган төгрөг хэмнэхээс 11,023.3 мянган төгрөгийг хэмнээгүй байна. | 11,023.3 | Зөвлөмж өгсөн | Захирал, нягтлан бодогч | Б.Март, У.Сүхбаатар |

**Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | | | |
|---|--|-----------------|-----------------|-------------------------|---------------------------|
| 7 | Тус байгууллага нь 2021 онд 579,802.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 516,591.1 мянган төгрөгийн 136 мэдээллийг хугацаанд нь, 63,211.2 мянган төгрөгийн 13 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна. | 63,211.2 | Зөвлөмж өгсөн | Захирал, нягтлан бодогч | Б.Март, У.Сүхбаатар |
| Заг сумын Цэцэрлэгийн зөрчлийн дүн | | 57,011.2 | | | |
| 8 | Нягтлан бодогчийн 1,3-р улирлын үр дүнгийн урамшуулал цалинг үндсэн орон тооны ажилтны цалингаас бодож 265.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 265.0 | Төлбөрийн акт | Эрхлэгч, нягтлан бодогч | Д.Оюунтөгс, У.Сүхбаатар |
| 9 | Ажилтнуудын цалингийн санг НДХ-т дутуу мэдээлсэн 1,254.5 мянга, илүү мэдээлсэн 549.0 мянга нийт 1,803.5 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна. | 1,803.5 | Албан шаардлага | Эрхлэгч, нягтлан бодогч | Д.Оюунтөгс, У.Сүхбаатар |
| 10 | Цалингийн зардлаас ажил олгогчийн төлөх 485.6 мянган төгрөгийг төлөөд тохируулах бичилтээр цалингийн зардалд хаасан, 12 дугаар сарын цалингаас суутгасан ҮЭТ-ын 86.0 мянган төгрөгийг төлөөгүй, өглөгөөр тусгаагүй байна. | 571.6 | Зөвлөмж | Эрхлэгч, нягтлан бодогч | Д.Оюунтөгс, У.Сүхбаатар |
| 11 | 2021.12.20-ны өдөр Өнөөгийн Баянхонгор сонины газарт /36*4500/ сонины үндэд 106.2 мянган төгрөгийг төсвөөс төлөөд суутган тооцоо хийгээгүй зардалд бичсэн | 106.2 | Төлбөрийн акт | Эрхлэгч, нягтлан бодогч | Д.Оюунтөгс, У.Сүхбаатар |
| 12 | Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлэл зохих 149 мэдээллээс 54264,9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн | 54,264.9 | Зөвлөмж | Эрхлэгч, нягтлан бодогч | Д.Оюунтөгс, У.Сүхбаатар |
| Заг сумын ЭМТ-ийн зөрчлийн дүн | | 51,315.3 | | | |
| 13 | Сумын Засаг даргын 2021.03.18-ны А/47 дугаар бүхий захирамжаар ЭМТ-ийн эмчлэгч эмчийн сул орон тооны ажлыг ЭМТ-ийн даргад түр хавсран гүйцэтгүүлсэн байна. Гэтэл ЭМТ-ийн даргын 2021.07.09-ний 35 дугаар тушаалаар эмчлэгч эмчээр Н.Ариунчимэгийг 2021.07.01-ний өдрөөс түр томилсон байхад О.Гэрэлчимэгт эмчлэгч эмчийн ажил хавсарсны нэмэгдэлд 7,8,9-р саруудад 785,6 мянган төгрөгийг олгосон байна. | 785.6 | | Дарга, нягтлан бодогч | О.Гэрэлчимэг, Ж.Дааханжав |
| 14 | 2021 оны 6-р сард аймгийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн анхан шатны баримттай 1916.0 мянган төгрөгийн автомашины 4ш дугуй, бусад хамгаалах хэрэгслийн хөдөлгөөний тайланг нярав гаргаагүй байна. | 1,916.0 | | Дарга, нягтлан бодогч | О.Гэрэлчимэг, Ж.Дааханжав |
| 15 | Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлэл зохих 149 мэдээллээс сар бүр мэдээлэх Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 9 дүгээр сарын 107918.6 мянган төгрөгийн үнийн дүнтэй 1, нийт 2 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 48,613.7 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | О.Гэрэлчимэг, Ж.Дааханжав |
| Заг сумын СХС-ийн зөрчлийн дүн | | 7,041.0 | | | |

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|------------------------------|--|----------------|---------------------------------|-----------------------------|--------------------------------|
| 16 | Тайлант оны эцэст 107,389.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 6664.6 мянган төгрөгийн авлага байна. Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлд нас барсан зээлдэгчийн 7041.0 мянган төгрөг байна. | 7,041.0 | Зөвлөмж өгсөн | Засаг дарга, нягтлан бодогч | Г.Нямжаргал, Э.Саруулсайхан |
| ОНХС-ийн зөрчлийн дүн | | 5,714.8 | | | |
| 17 | "Хогийн цэгийг дарж булшлах" төсөл арга хэмжээнд 50.0 сая төгрөг батлагдаж харьцуулалтын аргаар тенер зарлаж "Номгон такс констракшн" ХХК шалгарч гэрээг 2021.06.07-ны өдөр байгуулж 2021.07.30-ны өдөр дуусгахаар хийсэн байна. Ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгсөн харин гэрээнд хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг тодорхой тусгаагүй байна | 1,000.0 | Төлбөрийн акт | Засаг дарга, нягтлан бодогч | Г.Нямжаргал, Э.Саруулсайхан |
| 18 | Заг сумын ИТХ-ын Хуралдааны 2020.12.20-ны өгрийн 02/17 дугаар тогтоолоор батлагдсан ЭМТ-ийн Халдварт ноорог байшингийн дээврийн зураг төсөв гаргах" төсөр арга хэмжээний зардал 4714840 төгрөгийг Бумбат буурь ХХК-д 2021.07.28-ны өдөр шийлжүүлэн зураг төсвийг хийлгэсэн ба харин хөрөнгөд бүртгээгүй байна. | 4,714.8 | Санхүүгийн тайлангийн залруулга | Засаг дарга, нягтлан бодогч | Г.Нямжаргал, Э.Саруулсайхан |

оОо